

ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ

АУДИТЫН КОД: ТӨА-2023/32/-НА-СТА-ТШЗ

ТӨВ АЙМГИЙН ЗУУНМОД СУМЫН ХОТ ТОХИЖУУЛАХ ГАЗРЫН 2022
ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН
АУДИТЫН ТАЙЛАН

Зуунмод 2023 он



Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал

Утас: 70272582 Цахим хаяг: khishigjargalts@audit.gov.mn

Аудитын менежер О.Амаржаргал

Утас: 70273463 Цахим хаяг: amarjargalo@audit.gov.mn

Аудитор Б.Нямсүрэн

Утас: 70273465 Цахим хаяг: nyamsurenb@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу. Цахим хаяг: www.open.audit.mn

АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ.....	5
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	11
4. АУДИТЫН ТАЙЛАН	15
4.1 Ерөнхий зүйл.....	15
4.2 Материаллаг байдал.....	15
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	15
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	15
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	15
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	16
4.5.1 Завсрын аудитын талаар.....	16
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	16
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ.....	17

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



ТӨВ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

41100, Төв аймаг, Зуунмод сум
Утас: 70272582, Цахим шуудан: tuv@audit.gov.mn
Цахим хаяг: www.audit.mn

2023.02.25 № 01/121
танай -ны № -т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Төв аймгийн Зуунмод сумын Хот тохижуулах газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Төв аймгийн Зуунмод сумын Хот тохижуулах газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторов баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторов ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Төв аймгийн Зуунмод сумын Хот тохижуулах газар нь тайлант онд Хот тохижуулах газрын 30-н жилийн ойд зориулан тус байгууллагын эмэгтэйчүүдээс санаачлан зохион байгуулсан 2500-н мандлын цэцгийг үрслүүлж, Зуунмод сумын төвийн хэсгийн гудамжны шонд байрлуулах ажлыг хийж гүйцэтгэсэн байна. Одонт хөтөлд худалдаа үйлчилгээ явуулах 128м² талбайг хуучин явган замын хавтан тавьж засварласан байна. Мөн 16,17-р байрны хойд талын тоглоомын талбайг иж бүрэн засварлаж, тохижуулсан хэд хэдэн онцлог ажлууд хийгдсэн байна.

Аудитын гол асуудал

Санхүүгийн тайлангийн аудитад нөлөө үзүүлэх материаллаг буруу илэрхийлэл, нөлөө бүхий эрсдэл, удирдлагын үлэмж хэмжээний шийдэл орсон асуудал буюу нөлөө бүхий ажил гүйлгээ байхгүй байна.

Бусад асуудлын хэсэг

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ. Тус санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй болно

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.ХИШИГЖАРГАЛ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/			
Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	10,469,491.00	5,704,660.00
33	АВЛАГА	4,066,931.00	0
33500	Бусад авлага	4,066,931.00	0
33510	Байгууллагаас авах авлага	4,066,931.00	0
35	БАРАА МАТЕРИАЛ	6,402,560.00	5,704,660.00
35400	Хангамжийн материал	6,402,560.00	5,704,660.00
35410	Бичиг хэргийн материал	766,160.00	455,160.00
35420	Аж ахуйн материал	3,906,500.00	3,705,500.00
35430	Сэлбэг хэрэгсэл	1,342,450.00	1,241,800.00
35450	Барилгын засварын материал	387,450.00	302,200.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	3,279,371,507.81	3,363,891,294.66
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	3,279,371,507.81	3,363,891,294.66
39200	Биет хөрөнгө	1,905,056,507.81	1,989,576,294.66
39201	Барилга, байгууламж, орон сууц	2,678,615,372.15	2,787,335,836.35
39202	Хуримтлагдсан элэгдэл	-924,116,273.86	-919,034,830.03
39203	Авто-тээврийн хэрэгсэл	638,814,256.00	642,291,996.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-546,277,729.09	-579,980,967.61
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	38,110,019.54	43,439,919.54
39206	Хуримтлагдсан элэгдэл	-14,174,970.55	-21,746,243.37
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	22,256,663.00	32,339,163.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-16,311,396.69	-16,870,276.81
39209	Зам, гүүрийн байгууламж	56,918,608.00	56,918,608.00
39210	Хуримтлагдсан элэгдэл	-42,461,661.18	-45,988,177.10
39213	Түүх соёл, музейн дурсгалт зүйлс	10,499,100.00	10,499,100.00
39214	Бусад үндсэн хөрөнгө	104,473,812.00	104,935,812.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-101,289,291.51	-104,563,645.31
39300	Биет бус хөрөнгө	1,374,315,000.00	1,374,315,000.00
39301	Програм хангамж	400,000.00	400,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-400,000.00	-400,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	1,374,315,000.00	1,374,315,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	3,289,840,998.81	3,369,595,954.66
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	0	160,000.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	0	160,000.00
41300	Өглөг	0	160,000.00
41360	Бусад өглөг	0	160,000.00
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	0	160,000.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	3,289,840,998.81	3,369,435,954.66
51	Засгийн газрын хувь оролцоо	3,289,840,998.81	3,369,435,954.66
51100	Засгийн газрын оруулсан капитал	2,378,790,604.74	2,378,790,604.74
511002	Орон нутгийн төсвийн оруулсан хөрөнгө	2,378,790,604.74	2,378,790,604.74
51200	Хуримтлагдсан үр дүн	257,259,879.04	337,062,753.89
51210	Өмнөх үеийн үр дүн	409,076,131.93	257,467,798.04
51220	Тайлант үеийн үр дүн	-151,816,252.89	79,594,955.85
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	653,790,515.03	653,582,596.03
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	3,289,840,998.81	3,369,595,954.66

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	724,570,432.00	1,444,906,226.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	138,797,532.00	643,355,026.00
120	Нийтлэг татварын бус орлого	138,797,532.00	643,355,026.00
120009	Бусад орлого	0	4,066,931.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	137,830,032.00	639,288,095.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	967,500.00	0
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	585,772,900.00	801,551,200.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	585,772,900.00	801,551,200.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	585,772,900.00	801,551,200.00
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	876,386,684.89	1,026,579,930.53
21	УРСГАЛ ЗАРДАЛ	876,386,684.89	1,026,579,930.53
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	856,585,302.03	1,015,267,912.80
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	326,169,140.76	221,399,812.00
210101	Үндсэн цалин	296,101,730.76	221,399,812.00
210102	Нэмэгдэл	24,612,410.00	0
210103	Унаа хоолны хөнгөлөлт	5,455,000.00	0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	47,451,129.38	28,662,068.00
210201	Тэтгэврийн даатгал	36,541,830.74	21,032,982.00
210202	Тэтгэмжийн даатгал	2,491,864.05	2,213,997.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,308,563.36	1,771,198.00
210204	Ажилгүйдлийн даатгал	373,533.81	331,263.00
210205	Эрүүл мэндийн даатгал	3,735,337.42	3,312,628.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	13,250,549.00	61,065,295.00
210301	Гэрэл, цахилгаан	3,790,531.00	61,065,295.00
210302	Түлш, халаалт	8,640,408.00	0
210303	Цэвэр, бохир ус	819,610.00	0
2104	Хангамж, бараа материалын зардал	91,556,900.00	0
210401	Бичиг хэрэг	55,900.00	0
210402	Тээвэр, шатахуун	90,220,000.00	0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,181,400.00	0
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	99,600.00	0

2106	Эд хогшил, урсгал засварын зардал	15,267,445.00	0
210601	Багаж, техник, хэрэгсэл	11,652,000.00	0
210604	Урсгал засвар	3,615,445.00	0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	12,242,394.00	464,078,129.27
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	12,242,394.00	464,078,129.27
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	350,647,743.89	240,062,608.53
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	65,300,259.00	0
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	285,347,484.89	240,062,608.53
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	19,801,382.86	11,312,017.73
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	19,801,382.86	11,312,017.73
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	19,801,382.86	11,312,017.73
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	-151,816,252.89	418,326,295.47
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	0	338,731,339.62
225001	Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны гарз	0	338,731,339.62
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	-151,816,252.89	79,594,955.85

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/			
Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	585,772,900.00	805,618,131.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	0	4,066,931.00
120	Нийтлэг татварын бус орлого	0	4,066,931.00
120009	Бусад орлого	0	4,066,931.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	585,772,900.00	801,551,200.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	585,772,900.00	801,551,200.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	585,772,900.00	801,551,200.00
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	582,834,600.00	780,728,491.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	582,834,600.00	780,728,491.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	537,093,017.14	769,416,473.27
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	328,655,221.05	0
210101	Үндсэн цалин	260,635,449.05	0
210102	Нэмэгдэл	47,420,717.75	0
210103	Унаа хоолны хөнгөлөлт	20,599,054.25	0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	44,665,049.09	0
210201	Тэтгэврийн даатгал	27,455,725.18	0
210202	Тэтгэмжийн даатгал	3,258,648.35	0
210203	ҮОМШӨ-ний даатгал	8,561,126.72	0
210204	Ажилгүйдлийн даатгал	489,958.89	0
210205	Эрүүл мэндийн даатгал	4,899,589.95	0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	13,250,549.00	113,391,300.00
210301	Гэрэл, цахилгаан	3,747,521.00	113,391,300.00
210302	Түлш, халаалт	8,640,408.00	0
210303	Цэвэр, бохир ус	862,620.00	0
2104	Хангамж, бараа материалын зардал	92,212,000.00	0
210401	Бичиг хэрэг	1,008,600.00	0
210402	Тээвэр, шатахуун	90,000,000.00	0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,203,400.00	0
2105	Нормативт зардал	8,327,498.00	0
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	8,327,498.00	0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	30,000,000.00	0
210601	Багаж, техник, хэрэгсэл	30,000,000.00	0

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	0	656,025,173.27
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	0	656,025,173.27
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	19,982,700.00	0
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	19,982,700.00	0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	45,741,582.86	11,312,017.73
2132	Бусад урсгал шилжүүлэг	25,940,200.00	0
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	25,940,200.00	0
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	19,801,382.86	11,312,017.73
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	19,801,382.86	11,312,017.73
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	2,938,300.00	24,889,640.00
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	2,938,300.00	24,889,640.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	2,938,300.00	24,889,640.00
2200	Дотоод эх үүсвэрээр	2,938,300.00	24,889,640.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	2,938,300.00	24,889,640.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-2,938,300.00	-24,889,640.00

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

					/төгрөгөөр/
Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
1	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,378,790,604.74	656,665,559.50	406,201,087.46	3,441,657,251.70
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0	0	2,875,044.47	2,875,044.47
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	2,378,790,604.74	656,665,559.50	409,076,131.93	3,444,532,296.17
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	0	-2,875,044.47	0	-2,875,044.47
9	Тайлант үеийн үр дүн	0	0	-151,816,252.89	-151,816,252.89
10	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,378,790,604.74	653,790,515.03	257,259,879.04	3,289,840,998.81
11	2022 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	2,378,790,604.74	653,790,515.03	257,259,879.04	3,289,840,998.81
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0	0	207,919.00	207,919.00
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	2,378,790,604.74	653,790,515.03	257,467,798.04	3,290,048,917.81
14	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	0	-207,919.00	0	-207,919.00
19	Тайлант үеийн үр дүн	0	0	79,594,955.85	79,594,955.85
20	2022 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	2,378,790,604.74	653,582,596.03	337,062,753.89	3,369,435,954.66

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	801,551,200.00	1,425,441,646.54
21	УРСГАЛ ЗАРДАЛ	801,551,200.00	1,425,441,646.54
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	801,551,200.00	1,425,441,646.54
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	113,391,300.00	113,391,300.00
210301	Гэрэл, цахилгаан	113,391,300.00	113,391,300.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	688,159,900.00	1,312,050,346.54
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	688,159,900.00	1,312,050,346.54
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	801,551,200.00	801,551,200.00
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	801,551,200.00	801,551,200.00
320001	Орон нутгийн төсвөөс	801,551,200.00	801,551,200.00

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Төв аймгийн Зуунмод сумын Хот тохижуулах газар нь Зуунмод хотын хөгжлийн төлөвлөгөөнд тулгуурлан иргэдэд ая тухтай цэвэр үзэмжтэй, бохирдолгүй орчин бүрдүүлэх тохижилт үйлчилгээний ажил хийж гүйцэтгэх чиг үүрэг бүхий Төв аймгийн Зуунмод сумын Засаг даргын харьяа байгууллага юм.

Төв аймгийн Зуунмод сумын Хот тохижуулах газар нь 2022 оны байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөг 10 зорилтын хүрээнд 46 хэрэгжүүлэх арга хэмжээтэй боловсруулан баталснаас хэрэгжилт 94,2%-тай дүгнэгдсэн байна.

Төв аймгийн Зуунмод сумын Хот тохижуулах газар нь захиргааны аж ахуйн нэгж-7, ногоон байгууламж-15, хог хаягдал-22 гэсэн бүтэц, зохион байгуулалттай ба тайлант онд Зуунмод сумын Хот тохижуулах газрын дарга 1, гүйцэтгэх 6, үйлчилгээний ажилтан 37 бүгд 44 орон тоотойгоор үйл ажиллагаагаа явуулсан байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна. Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Төв аймгийн Зуунмод сумын Хот тохижуулах газар нь төсвийн шууд захирагчийн хувьд дараах хуулийн хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Төрийн хяналт шалгалтын тухай хууль
- Монгол Улсын 2022 оны Төсвийн тухай хууль
- Төрийн хэмнэлтийн тухай хууль
- Хог хаягдлын тухай хууль

Төв аймгийн Зуунмод сумын Хот тохижуулах газрын даргын 2022 оны 4 дүгээр сарын 25-ны өдрийн "Дотоод хяналт шалгалтын ажилтанг томилох тухай" А/09 тушаал, 5 хүний бүрэлдэхүүнтэй, Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолын дагуу үйл ажиллагаа явуулж байна.

Төв аймгийн Зуунмод сумын Хот тохижуулах газрын дотоод хяналт шалгалтын хороо нь тайлант онд дотоод хяналт шалгалт явуулахаар 18 арга хэмжээг улирал бүр, хагас, бүтэн жилээр төлөвлөн санхүү төсөв, эд хөрөнгийн ашиглалтын талаар болон шилэн дансны хуулийн хэрэгжилт, хог хаягдлын ачилтын үйл ажиллагааны чиглэлээр хийж хэрэгжилтийг гарган ажилласан байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Байгууллагын дотоод хяналт шалгалтын хороо ажилчдын нийгмийн хамгааллын байдал, шилэн дансны хөтлөлт, байгууллагын дотоод журам, хөдөлмөрийн гэрээний хэрэгжилт, аудитын өгсөн зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавих төлөвлөгөөг боловсруулан ажилласан бөгөөд ажлын байрны тодорхойлолт, ажил үүргийн хуваарьт тусгасан болно.

Байгууллагын дотоод хяналт шалгалтын хороо нь жилийн төлөвлөгөөний дагуу төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус хяналт шалгалт санхүүгийн үйл ажиллагаанд хийж, алдаа зөрчил гарвал тухай бүрд нь засаж залруулах зөвлөмж өгч эргэн хяналт тавьж ажилласан байна.

Төлөвлөлтийн үе шатанд дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзсэн.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Төв аймгийн Зуунмод сумын Хот тохижуулах газар нь 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна. Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Төв аймгийн Зуунмод сумын Хот тохижуулах газар нь 2022 оны санхүүгийн тайлангаа Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна. Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 79,755.0 мянган төгрөгөөр буюу 2,4 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

			/мянган төгрөгөөр/
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	0	0	0
Авлага	0	0	0
Бараа материал	6,402.6	5,704.7	-697.9
Үндсэн хөрөнгө	3,279,371.5	3,363,891.3	84,519.8
Нийт хөрөнгө	3,289,841.0	3,369,596.0	79,755.0
Өр төлбөр	0	160.0	160.0
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	3,289,841.0	3,369,436.0	79,595.0
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	3,289,841.0	3,369,596.0	79,755.0

Дээрх хүснэгтээс харахад, өмнөх оны үзүүлэлтээс нөлөө бүхий өөрчлөлт гараагүй. Үндсэн хөрөнгийн дансанд орлого зарлагын хөдөлгөөн хийгдсэн болон хөрөнгийн элэгдлийн зардлаас

шалтгаалан өмнөх оны үзүүлэлтээс 84,519.8 мянган төгрөгөөр нэмэгдсэн байна. Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 3,369,436.0 мянган төгрөг болж 79,595.0 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ.

Өглөгийн данс 160.0 мянган төгрөгийн эцсийн үлдэгдэлтэй болсон нь хувь хүмүүст төлөх өглөг байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 937,873.9 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төв аймгийн Зуунмод сумын Хот тохижуулах газраас дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн төсвийн төслөөс 136,322.7 мянган төгрөгөөр бууруулан Төв аймгийн Зуунмод сумын ИТХ-ын 2021 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн 01 дугаар албан бичгийн хавсралтаар 2022 оны урсгал зардлын төсвийг 801,551.2 мянган төгрөгөөр баталж ирүүлсэн.

Энэ нь 2022 оны төсвийн төслийг бодитой, үндэслэлтэй боловсруулаагүй эсвэл тухайн байгууллагын төсвийн төсөлд хүргүүлсэн саналд үндэслэлгүй баталдгаас шалтгаалсан байна.

Тайлант хугацаанд батлагдсан төсөвт тодотгол, өөрчлөлт ороогүй байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 /хот байгуулалт, тохижилт/ хөтөлбөрийн 3 арга хэмжээг санхүүжүүлэхээр 801,551.2 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр батлагдсаны дагуу гүйцэтгэлээр санхүүжилтийг 100 хувь олгож, оны эцэст зарцуулаагүй үлдэгдэл 11,312.0 мянган төгрөгийг төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Тайлант хугацааны төсвийн нийт зардлын гүйцэтгэл 794,306.1 мянган төгрөг буюу 99,1 хувьтай байгаа нь үндсэн үйл ажиллагааны зардлын төсвийг 11,312.0 мянган төгрөгөөр тус тус дутуу зарцуулсантай холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/					
д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	71502 хот байгуулалт, тохижилт 82203 нийтийн эзэмшлийн гудамж талбай	113,391.3	113,391.3	0	100
2	71502 хот байгуулалт, тохижилт 82204 нийтийн эзэмшлийн гудамж талбай	568,159.9	560,951.0	11,275.9	98,7
3	71502 хот байгуулалт, тохижилт 82212 хур хог хаягдал, орчны бохирдол	120,000.0	119,963.9	36.1	99,9

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Төв аймгийн Зуунмод сумын Хот тохижуулах газрын нэмэлт санхүүжилтийн дансанд орлого төвлөрөөгүй болно.

3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тус төсөл хэрэгжих хугацаанд нийт 1 хөтөлбөрийн 3 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна.

Хүснэгт 3. Төсөл хөтөлбөрийн арга хэмжээний хүрэх үр дүн, биелэлт

/мянган төгрөгөөр/						
№	Хөтөлбөр	Хэрэгжих хугацаа	Хүрэх үр дүн	Хэрэгжилтийн явц	Зарцуулах төсөв	Зарцуулсан
1	71502	2022.01.01-2022.12.31	Хот байгуулалт, тохижилт	Хөтөлбөр 99,1 %	801,551.2	794,306.1

Төв аймгийн Зуунмод сумын Хот тохижуулах газар нь төсвийн хэмнэлтийн горимд шилжин ажилласнаар нийт 11,312.0 мянган төгрөгийн зардлыг хэмнэж, дутуу зарцуулсан нь хөтөлбөрийн хэрэгжилтэд нөлөөлсөн байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Төв аймгийн Зуунмод сумын Хот тохижуулах газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Төв аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Б.Нямсүрэн гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер О.Амаржаргал, дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал нар тус тус хэрэгжүүлсэн.

Төв аймгийн Зуунмод сумын Хот тохижуулах газрын 2022 оны санхүүгийн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайланг Төв аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 01 дүгээр сарын 24-ны өдрийн 04 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр Төв аймгийн Зуунмод сумын ИТХ-ын 2022 оны баталсан төсвийн нийт зарлагыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1,5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг Төв аймгийн Зуунмод сумын Хот тохижуулах газрын төсвийн гүйцэтгэлийн тайлангийн батлагдсан 2022 оны нийт зарлага 801,551.2 мянган төгрөгөөс 1,5 хувиар буюу 12,023.3 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 9,017.5 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төв аймгийн Зуунмод сумын Хот тохижуулах газар нь тайлант онд Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор авч хэрэгжүүлсэн арга хэмжээ байхгүй байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Төв аймгийн Зуунмод сумын Хот тохижуулах газрын шилэн дансны хуулийн хэрэгжилтийг шалгахад Цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 36 орлогын, 21 зарлагын мөнгөн гүйлгээг болон өмч хөрөнгө, мөнгө зарцуулах шийдвэрийг хугацаандаа байршуулсан байна.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Тус байгууллагад бусад хууль тогтоомжийн хүрээнд шийдвэрлэх алдаа, зөрчилтэй асуудал гараагүй байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Төв аймгийн Зуунмод сумын Хот тохижуулах газрын эхний хагас жилийн байдлаарх санхүүгийн тайланд завсрын аудит хийгдсэн. Завсрын аудитын явцад алдаа, зөрчил илрээгүй тул асуудлын бүртгэл хөтлөөгүй болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Тус байгууллага нь 2021 оны санхүүгийн тайлангийн 1 төлбөрийн акт, 1 албан шаардлага, 1 зөвлөмж өгөгдсөнийг 100% хэрэгжүүлэн, биелэлтийг 2022 оны 6 дугаар сарын 14-ны өдрийн 28 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	1	1,343.9	1	1,343.9	100
Албан шаардлага	1	56,799.6	1	56,799.6	100
Зөвлөмж					
Нийт дүн	2	58,143.5	2	58,143.5	100

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Төв аймгийн Зуунмод сумын Хот тохижуулах газрын дараагийн аудитаар анхаарал татахуйц асуудал байхгүй.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

5.1 Залруулсан алдаа

Аудитаар нийт 11,312.0 мянган төгрөгийн алдаа¹ илэрснээс аудитын явцад 11,312.0 мянган төгрөгийн алдааг залрууллаа.Үүнд:

1. Орон нутгийн төсөвт төвлөрүүлэх шилжүүлгийг, улсын төсвөөс олгосон санхүүжилт шилжүүлэг дансанд 11,312.0 мянган төгрөгөөр буруу тайлагнасан байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-т “холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 5.1.3-д жинхэнэ хэрэгжилтийн зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлнө” гэж заасныг болон санхүүгийн тайлангийн “тохиолдсон байх”, “нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т “Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна” гэсэн заалтын дагуу гүйцэтгэлийн үе шатанд залруулга хийгдсэн.

5.3 Зөвлөмж

1. Нийцлийн аудиттай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Шилэн дансны цахим хуудсанд 2022 онд нийт мэдээлбэл зохих 171 мэдээллээс хугацаа хоцроосон 6 мэдээлэл, хандив, тусламжийн хэмжээ, түүний зарцуулалтын тайланд 4 мэдээллийг огт мэдээлээгүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3-т “Тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх” гэсэн заалт болон санхүүгийн тайлангийн аудитын “нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Шилэн дансанд байршуулбал зохих мэдээллийг үнэн зөв, бүрэн гүйцэд, тухай бүр мэдээлж байх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төв аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 6 дугаар сарын 10-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

